

ХҮНИЙ НӨӨЦИЙН НИЙГМИЙН БАТАЛГАА ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ
2023-2024 ОНЫ ТАЙЛАН

2025.04.17

Д/Д	Зорилт, үйл ажиллагаа	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь
Зорилт-1: Орон нутгийн хөгжилд хувь нэмрээ оруулах, өндөр чадамжтай боловсон хүчнийг салбар бүрд тасралтгүй бэлтгэж, боловсон хүчний хангалтыг 2027 онд 98 хувьд хүргэнэ зорилтын хүрээнд:				
1	1.1 Орон нутагт хэрэгцээтэй боловсон хүчнийг хүний нөөцийн суурь судалгаанд тулгуурлан шинээр бэлтгэнэ.	1.1.1 Аймгийн хэмжээнд шаардлагатай ажлын байрны хэрэгцээний судалгааг жил бүр салбар, чиглэлээр нь гаргах	Аймгийн хэмжээнд нэн шаардлагатай буюу сул орон тооны судалгааг 2023, 2024 онд тус бүр 1 удаа авсан. 2023 онд уг судалгааг аймгийн хэмжээний бүх төрийн байгууллагаас авсан ба багш мэргэжлийн 31, хүний их эмч 27, сувилагч 37, эмнэлгийн ажилтан 9, эм зүйч 2, байгаль орчны мэргэжилтэн 6, мал аж ахуйн мэргэжилтэн 17, бэлчээр, газар тариалангийн мэргэжилтэн 3, газрын кадастр, даамал 4, нийгмийн ажилтан 3, сэтгэл зүйч 6, санхүү, нягтлан бодогч 2, соёл урлаг 9, хоол зүйч 4, архив, бичиг хэргийн ажилтан 1, инженер 3, хууль, эрх зүй 2 нийт 166 сул орон тоо байсан. 2024 оны 6 дугаар сарын судалгаагаар багш мэргэжлийн 30, хоол зүйч 2, сэтгэл зүйч 2, инженер 3, их эмч 11, сувилагч 5, эмнэлгийн ажилтан 5, эм зүйч 1, бага эмч 4, мал аж ахуйн чиглэлийн мэргэжилтэн 10, газар тариалангийн мэргэжилтэн 3, байгаль хамгаалагч 4, газрын мэргэжилтэн 8, санхүү 5 орон тоо байгаа нь хүний нөөцийн нөхөн хангалтын дундаж 57 хувь байна.	100
		1.1.2 Орон нутагт эрэлттэй мэргэжлийн танилцуулга, уулзалт хэлэлцүүлэг, үзүүлэх сургалт, контент бэлтгэх ажлыг тогтмол зохион байгуулах	“Нутгийн хөгжилд хамтдаа-Сүхбаатарын оюутнууд 2023” арга хэмжээг Улаанбаатар хотод зохион байгуулж 400 гаруй оюутан оролцон, хөгжил дэвшлийг түүчээлэн явах нутгийн залуучуудтай аймаг, сумын хөгжилд залуучуудын оролцоо, тулгамдаж буй асуудлын талаар санал солилцсон. Уг арга хэмжээний	100

			үеэр орон нутагт нэн шаардлагатай байгаа ажлын байрны талаар холбогдох байгууллагууд оюутан залууст мэдээлэл хийж тэднийг орон нутагтаа ирж ажиллах талаар уриалан, тэднийг байгууллага орон нутгаас дэмжиж ажиллах талаар мэдээлэл өглөө.	
		1.1.3 Орон нутагт нэн хэрэгцээтэй мэргэжлийн элсэлтийн хуваарийн захиалгыг их дээд сургууль болон яам холбогдох байгууллагад хүргүүлэн, оюутан элсүүлэх	2025 онд хамтран ажиллахаар төлөвлөж байна	Хэрэгжих хугацаа болоогүй
		1.1.4 Аймагт хэрэгцээтэй ХАА, МАА, Эрүүл мэнд, боловсрол, соёл, байгаль орчны чиглэлийн мэргэжлийн боловсон хүчнийг орон нутгийн захиалгаар бэлтгэх	Орон нутагт нэн шаардлагатай хүний нөөцийг бэлтгэх зорилгоор хөтөлбөрийн хүрээнд 2023, 2024 онд сувилагч бэлтгэх сургалтад 46 иргэнийг хамруулж сургалтын төлбөрт 74631,000 төгрөг зарцуулаад байна.	100
		1.1.5 Орон нутгаас их дээд сургуульд суралцаж байгаа оюутнуудын судалгааг гаргаж, орон нутагтаа ирж ажиллах талаар уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах	“Нутгийн хөгжилд хамтдаа-Сүхбаатарын оюутнууд 2023” арга хэмжээг Улаанбаатар хотод зохион байгуулж 400 гаруй оюутан оролцсон ба уг арга хэмжээний бэлтгэл ажлын хүрээнд Эрүүл мэндийн газар, аймгийн Нэгдсэн эмнэлэг ангаах ухааны чиглэлээр, аймгийн Мал эмнэлгийн газар мал эмнэлгийн чиглэлээр суралцаж буй оюутны судалгааг гарган тэдэнтэй уулзалт зохион байгууллаа.	100
		1.1.6 Аймагт нэн шаардлагатай мэргэжлээр суралцаж буй залуучуудыг нутагтаа ирж ажиллах гэрээ байгуулан сургалтын төлбөрийн тэтгэлэг үзүүлэх	Орон нутагт нэн шаардлагатай мэргэжлээр суралцаж буй 10 оюутанд сургалтын төлбөрийн тэтгэлэг өгөхөөр зарласан ба шаардлага нөхцөлийг хангасан 3, 4-р курсийн 8 оюутанд 32,0 сая төгрөгийн сургалтын төлбөрт тус бүр 4 сая төгрөгийн тэтгэмжийг олгоод байна. Эдгээр 8 оюутантай аймаг орон нутагтаа 5 жил ажиллах гэрээг байгуулаад байна. 2024 онд төгссөн 2 оюутан орон нутагтаа ажиллаж байна.	100
2	1.2. Төрийн захиргааны албан хаагчдад тавигдах ерөнхий болон тусгай	1.2.1 Байгууллага, сум бүр төрийн захиргааны албан хаагчдад тавигдах ерөнхий болон тусгай шаардлага хангасан хүний нөөцийн сан бүрдүүлнэ.	Төрийн байгууллага бүр өөрийн салбарт нэн шаардлагатай байгаа хүний нөөцийн нөхөн хангалтыг хийх, тэдний судалгаа мэдээллийн сантай болох талаар заавар зөвлөмжийг 2024 онд сумын Засаг	100

	шаардлага хангасан хүний нөөцийн санг байгууллага бүр бүрдүүлэн, төрийн албанд шинээр орж байгаа залуу албан хаагчдыг чадавхжуулна.		даргын Тамгын газрын дарга нарт зохион байгуулсан сургалтын үеэр, мөн Хүний нөөцийн клубийн уулзалт, сургалтын үеэр төрийн байгууллагын хүний нөөцийн ажилтан нарт өгч ажиллалаа. Энэхүү ажлын хүрээнд 2024 онд сул орон тооны нөхөн хангалтын хувь 2023 онд 94 хувьтай байсан 2024 онд 96 хувьтай болсон байна.	
		1.2.2 Төрийн байгууллагууд шинэ албан хаагчийг дадлагажуулах хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх	Аймгийн Засаг даргын Тамгын газрын “Шинэ ажилтныг дадлагажуулах хөтөлбөр”-ийг 2022 онд боловсруулан баталж, хэрэгжүүлэн ажиллаж байна. Энэхүү хөтөлбөрийн талаарх мэдээллийг 2023 онд Хүний нөөцийн клубийн гишүүдэд чадавхжуулах сургалтын үеэр хийж, өөрийн байгууллагын онцлогт тохируулан боловсруулах зөвлөмжийг өгөн ажиллалаа. Мөн Хүний нөөцийн клубийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд аймгийн хэмжээний шинэ ажилтныг дадлагажуулах хөтөлбөрийг боловсруулан, хэрэгжүүлж ажиллахаар тусгаад байна.	100
		1.2.3 Хүний нөөцийн ил тод байдлыг сайжруулан, улс төрөөс ангид байж, сонгон шалгаруулалтын ил тод байдлыг хангах	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн дагуу сонгон шалгаруулалтыг зарлаж, томилж байхыг жил бүр удирдах ажилтны зөвлөгөөний үер үүрэг чиглэл өгч ажиллаж байна. 2024 оны 4-р сард Төрийн албаны зөвлөлөөс төрийн захиргааны албан хаагчдын сонгон шалгаруулалт болон томилгооны талаарх хуулийн хэрэгжилтэд хяналт, шалгалтыг зохион байгуулсан. Уг хяналт, шалгалтад аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагууд хамрагдсан ба зөрчилтэй буюу хууль бус томилгоо нийт 7 зөрчил илэрсэн нь төрийн албаны тусгай сонгон шалгаруулалт зарлаагүй томилсон 4, аймаг, сумын ИТХ-ын төлөөлөгч төрийн захиргааны албан тушаал хашиж буй зөрчил 3 байсныг арилган Төрийн албаны зөвлөлд тайланг хүргүүлэн ажиллалаа.	100

3	1.3. Чадварлаг, нарийн мэргэжлийн боловсон хүчин, зөвлөхүүдийг орон нутагтаа урьж нийгмийн баталгааны дэмжлэг үзүүлнэ.	1.3.1 Зөвлөх, мэргэжилтэн шаардлагатай салбар, байгууллагуудын судалгаа гаргах	Орон нутагт нэн шаардлагатай мэргэжилтэн бэлтгэх ажлын хүрээнд гарсан судалгааны дүнд төгсөх ангийн сурагчдыг байгалийн ухааны чиглэлээр бэлтгэх нэн шаардлагатай байгаа нь тогтоогдсон тул энэ чиглэлийн багш нарыг урьж, дэмжин ажиллах талаар Ерөнхий боловсролын сургуулиудтай харилцан ярилцан физик, хими биологи болон математикийн чиглэлээр зөвлөх багш ажиллууллаа.	100
		1.3.2 Зөвлөхүүдийг урьж гэрээ байгуулан хамтран ажиллах	Орон нутагт нэн шаардлагатай мэргэжилтний судалгаа болон ерөнхий боловсролын сургуулийн саналын дагуу Математик, хими, физикийн зөвлөх багш нарыг дэмжин хамтран ажиллалаа. Уг ажлын хүрээнд орон нутгийн чадвартай мэргэжлийн багш нарыг дэмжин 2023-2024 оны хичээлийн жилд дээр чиглэлээр суралцаж буй сурагчдад үнэ төлбөргүй нэмэлт сургалт өгөхөд нь зориулан 3 багшид 60 сая төгрөгийн дэмжлэг, урамшууллыг олгоод байна. Элсэлтийн ерөнхий шалгалтын дүнгээр математик 2022 онд 6, 2023 онд 1, 2024 онд 1-р байрт орж сүүлийн 2 жил байраа хадгалсан бол физикийн дүнгээр 2022 онд 17, 2023 онд 14, 2024 онд 3-р орж ахиулсан үзүүлэлтэй байна. Химийн хичээлийн дүнгийн хувьд 2022 онд 9, 2023 онд 9, 2024 онд 13-р байранд орж амжилт буурсан үзүүлэлттэй байна.	100
		1.3.3 Мэргэжилтнүүдийг ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлнэ.	Аймгийн сурагчдын сургалтын чанарыг дээшлүүлэх, бусад багш нартай заах арга барилын талаар туршлага солилцох, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор Улаанбаатар хотод ажиллаж байсан 1 математикийн багшийг ерөнхий боловсролын сургуульд ажиллуулахаар урьж, түүний тогтвортой ажиллах нөхцөлийг хангах зорилгоор 20 сая төгрөгийн орон сууцны дэмжлэгийг олгоод байна.	100

Зорилт-2 Хүний нөөцийн ажиллах орчин нөхцөл, нийгмийн баталгааны дэмжлэгийг 30 хувиар нэмэгдүүлж, мэргэшсэн, тогтвортой, хариуцлагатай төрийн албыг бэхжүүлнэ зорилтын хүрээнд:

4	2.1. Төрийн албан хаагчдын техник, тоног төхөөрөмжийн хангалтыг сайжруулан ногоон оффис бүхий ажиллах орчныг бүрдүүлнэ.	2.1.1 Төрийн албан хаагчдын техник, тоног төхөөрөмжийн судалгаа, хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх	Төрийн албан хаагчдыг орчин үеийн шаардлага хангасан техник, тоног төхөөрөмжөөр хангаж ажиллахыг төрийн байгууллага бүр өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан шийдвэрлэж ажиллахыг үүрэг болгон ажиллаж байна. Энэхүү ажлын хүрээнд аймгийн Засаг даргын Тамгын газарт хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг 2023 онд “МСН” үнэлгээний төвөөр хийлгэн холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна. Энэхүү хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээгээр Тамгын газрын нийт албан хаагчдын өрөөний гэрэлтүүлэг муу, тоосжилт их, агаар сэлгэлт тааруу гэх мэт зөвлөмжийн хүрээнд шаардлагатай өрөө тасалгааны гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх, удаан хугацаанд хэрэглэсэн буюу хуучирч муудсан хивс, хивсэнцрийг авч шалыг засварлах ажлыг хийж гүйцэтгэсэн	100
		2.1.2 Төрийн албан хаагчдын ногоон оффис бүхий ажиллах орчин нөхцөлийг сайжруулах, техник, тоног төхөөрөмжөөр хангах	Төрийн байгууллага, албан хаагчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулах, төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор зарим байгууллагад тоног төхөөрөмж худалдан авахад нь дэмжлэг үзүүлээд байна. Уг дэмжлэгт нийт 48,5 сая төгрөг зарцуулсан.	100
		2.1.3 Ногоон ажлын байр бий болгох санал санаачилгыг дэмжих	Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах чиглэлээр хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэхийг бүх төрийн байгууллагад үүрэг чиглэл өгөн ажиллаж байна.	30
		2.1.4 Төрийн байгууллагуудад ISO стандарт нэвтрүүлэх	2024 оны байдлаар Чанарын менежментийн тогтолцоо ISO9001:2015 стандартыг Баруун-Урт, Мөнххаан сумын Засаг даргын Тамгын газрууд нэвтрүүлээд байгаа ба Баруун-Урт сумын Засаг даргын Тамгын газар албан ёсоор баталгаажуулалт хийлгэж гэрчилгээ аваад байна. Мөнххаан сумын Засаг даргын Тамгын газрын хувьд нэвтрүүлэх үе шатны сүүлийн хэсэгт явж байна. Мөн Монгол Улсын урт богино хугацааны бодлогын баримт бичигт туссаны дагуу бүх төрийн	100

			байгууллага болон сумын Засаг даргын Тамгын газарт энэхүү стандартыг нэвтрүүлэхийг үүрэг болгоод байна.	
		2.1.5 Хөдөө орон нутагт ажиллаж байгаа төрийн албан хаагчдын гэр бүлийг нь нэн тэргүүнд ажлын байраар хангах бодлого баримтлах	Аймгийн сурагчдын сургалтын чанарыг дээшлүүлэх, бусад багш нартай заах арга барилын талаар туршлага солилцох, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор Улаанбаатар хотод ажиллаж байсан 1 математикийн багшийг ерөнхий боловсролын сургуульд ажиллуулахаар урьж, түүний тогтвортой ажиллах нөхцөлийг хангах зорилгоор 20 сая төгрөгийн орон сууцны дэмжлэгийг олгоод байна. Мөн сумын өрхийн эрүүл мэндийн төвийн лаборант өөр орон нутгаас шилжин ирсэн 1 албан хаагчид орон сууцны дэмжлэгийг үзүүлээд байна.	100
5	2.2 Төр, хувийн хэвшлийн уялдаа, хамтын ажиллагааг сайжруулж хүний нөөцийн нийгмийн баталгааг хангах чиглэлээр гаргасан санал санаачилгыг дэмжин хамтарч ажиллах	2.2.1 Хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран төрийн албан хаагчийг чадавхжуулах, нийгмийн баталгааг сайжруулах төсөл хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэх, дэмжих	Төрийн албан хаагчийг чадавхжуулах, нийгмийн баталгааг сайжруулах төсөл, хөтөлбөр, арга хэмжээг дэмжин ажиллах боломжтой талаар хувийн хэвшлийн байгууллагууд болон бүх төрийн байгууллагуудад мэдээлэл өгсөн.	Хэрэгжих хугацаа болоогүй
		2.2.2 Хувийн хэвшил, олон нийттэй хамтран төсөл арга хэмжээ санаачлан хэрэгжүүлсэн албан хаагчийг урамшуулах	Одоогоор энэ чиглэлээр хамтарч ажилласан, санал санаачлаг хэрэгжүүлсэн албан хаагч байхгүй болно	Хэрэгжих хугацаа болоогүй
6	2.3 Орон сууцны нөхцөлөө сайжруулах, өрхийн амьжиргааг дээшлүүлэхэд бодитой дэмжлэг үзүүлнэ.	2.3.1 Хүний нөөцийн суурь судалгаа, жендер, ажлын бүтээмжийг үндэслэн төрийн албан хаагчдыг үе шаттай орон сууцны дэмжлэг үзүүлэх	2023-2024 онд орон нутагт нэн шаардлагатай ажлын байранд ажиллаж буй албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх, дэмжин ажиллах бодлогын хүрээнд 7 багш, 2 сувилагч гэр бүлд, сумын өрхийн эрүүл мэндийн төвийн лаборант 1 албан хаагчид орон сууцны дэмжлэг үзүүлээд байгаа ба нийт дэмжлэг олгосон албан хаагчдын 33 хувийг эрэгтэй албан хаагч эзэлж байна.	100
		2.3.2 Орон нутагт хэрэгцээтэй нарийн мэргэжлийн албан хаагч УБ-аас аймагт,	Түмэнцогт сумын өрхийн эрүүл мэндийн төвийн лаборантаар өөр орон нутгаас шилжин ирсэн 1 албан хаагчид орон сууцны дэмжлэгийг үзүүлээд байна.	100

7		аймгийн төвөөс суманд ажиллахад орон байрны дэмжлэг үзүүлнэ.		
		2.3.3 Төрийн албан хаагчдыг өрхийн амьжиргаагаа дээшлүүлэхэд зориулан дэмжлэг үзүүлэх	Бүх төрийн байгууллагуудад албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр боловсруулж, хэрэгжилтийг нь хангаж ажиллахыг үүрэг болгоод байна. Мөн хөтөлбөрт туссан энэхүү арга хэмжээг хэрэгжүүлэхээр “Хүний нөөцийн сургалт хөгжил, нийгмийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлэх журам”-ыг боловсруулж, хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.	30
	2.4. Төрийн албан хаагчдыг мэдлэг чадвараа дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлж, мэдлэг боловсролтой, ёс зүйтэй төрийн албыг бэхжүүлнэ.	2.4.1 Сургалтын хэрэгцээнд үндэслэн сургалт хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх	Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт албан хаагчдын мэдлэг ур чадварын талаарх судалгаа авах, сургалт хөгжлийн хөтөлбөр боловсруулах ажлыг тусгаад байна.	50
		2.4.2 Жил бүр төрийн албаны зөвлөгөөн зохион байгуулж, харилцан туршлага солилцон, тэргүүний арга туршлагыг түгээн дэлгэрүүлэх, харилцан суралцах сургалт, арга хэмжээг зохион байгуулж хэвшүүлэх	2024 онд аймгийн төрийн болон орон нутгийн өмчит байгууллагуудын хүний нөөц хариуцсан ажилтан нарын нэгдсэн зөвлөгөөнийг зохион байгуулж, тэднийг сургаж хөгжүүлэх, харилцан туршлага судлах арга хэмжээг зохион байгуулсан ба уг арга хэмжээнд хөтөлбөрийн хүрээнд 5,5 сая төгрөгийн дэмжлэгийг үзүүлээд байна. Мөн төрийн байгууллагын бүсийн салбар дундын зөвлөгөөнийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэн хамтран ажиллаж байна. Энэхүү сургалт, зөвлөгөөнүүдэд нийт 19,5 сая зарцуулаад байна.	100
		2.4.3 Төрийн албан хаагчдыг дээд шатны байгууллагын тэргүүний арга туршлага, аймаг орон нутгийн төрийн байгууллагуудад туршлага судлах боломжийг дэмжих	2023-2024 онд энэхүү арга хэмжээний хүрээнд дэмжлэг хүссэн байгууллага, албан хаагч байхгүй болно.	100
		2.4.4 Жил бүр 5-аас доошгүй албан хаагчдын гадаадын өндөр хөгжилтэй оронд туршлага судлах, сургалт арга хэмжээнд оролцуулах боломжийг судлан хэрэгжүүлэх	Төрийн албан хаагчдын мэдлэг ур чадварыг дээшлүүлэх, гадаад улс, орны хөгжил, туршлагаас суралцах, хамтын ажиллагааны хүрээнд уулзалт, зөвлөгөөнд 9 албан хаагчийг хамрууллаа. Уг сургалт, уулзалт зөвлөгөөнд 10 сая төгрөг зарцуулаад байна. Дээрх арга хэмжээнүүдэд оролцсон албан хаагчдаас удирдах албан тушаалтан 89 хувийг эзэлж байна.	100

		2.4.5 Өөрийн эрхэлсэн ажлын чиглэлээр дүн шинжилгээ хийх, онол арга зүйн үндсийг боловсруулах судалгаа хийх чадавхыг эзэмших нөхцөл боломжийг бүрдүүлнэ.	Аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгахаар төлөвлөөд байна	Хэрэгжих хугацаа болоогүй
		2.4.6 Эх хэлээ төгс эзэмшиж ашиглах, бичих, илтгэх ур чадварыг хөгжүүлж, ажилтан бүр “Эх бичгээ дээдлэх” хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлнэ.	2023-2024 онуудад монгол хэлний багш нарын дунд “Монгол бичгийг дээдлэгч багш” мэргэжлийн багш нарын дунд уралдаан зарлаж 3 багшийг шагнаж, урамшуулсан. Мөн “Жаахан шаргын нутаг”, “Хос бичигтэн байгууллага” уралдаан болон “Монгол бичгээр цахимд бичих арга зүй”, “Монгол бичгээр баримт бичих үйлдэх стандарт”- монгол бичгийн сургалтуудыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэн ажилласан.	100
		2.4.7 Жил бүр төрийн албан хаагчийн ёс зүйн аяныг өрнүүлэн дүгнэж байх	2025 оныг “Төрийн албан хаагчийн ёс зүй, хариуцлага, нийгмийн баталгааг дээшлүүлэх” жил болгон зарлаад байна. Энэхүү жилийн арга хэмжээний төлөвлөгөөнд тусган ажиллаж байна.	Хэрэгжих хугацаа болоогүй
		2.4.8 Нийтийн биеийн тамир, спортын олон төрөлт тэмцээн уралдаан зохион байгуулж, төрийн албан хаагчдын эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийг тогтмолжуулан бие бялдар, эрүүл мэндээ сайжруулах санал санаачилгыг дэмжиж ажиллах	Албан хаагчдын нийгмийн баталгааг чиглэлээр байгууллага бүр өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан спортын тэмцээн уралдаан зохион байгуулах, албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна. Аймгийн “Албан хаагчдын нийгмийн баталгаа хангах хөтөлбөр”-ийн хүрээнд Боловсрол, эрүүл мэндийн салбарын албан хаагчдын спортын тэмцээнд дэмжлэг үзүүлэн хамтран ажилласан. Энэхүү дэмжлэгт нийт 13,6 сая төгрөг зарцуулаад байна.	100
8	2.4 Төрийн албан хаагчийн хариуцлагыг өндөржүүлэн, шударга үнэлгээний тогтолцоог	2.5.1 Шинэ санаачилга, ажлын сайн арга туршлагыг илрүүлэх арга хэмжээг зохион байгуулж, албан хаагчдыг урамшуулан, туршлагыг түгээн дэлгэрүүлэхэд дэмжлэг үзүүлэх	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 205 дугаар тогтоолоор төрийн албаны өдөртэй болсонтой холбогдуулан 2025 оноос энэхүү арга хэмжээг зохион байгуулахаар төлөвлөөд байна	Хэрэгжих хугацаа болоогүй

	бүрдүүлж, урамшуулна.	2.5.2 Ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөө, хөдөлмөрийн гэрээний биелэлтийг хагас бүтэн жилээр үнэлж, дүгнэн, үнэлгээний мөрөөр шагнаж урамшуулах, хариуцлага тооцох	Өөрийн салбар, байгууллагадаа тогтвор суурьшилтай ажиллаж, эрхэлсэн ажилдаа амжилт гаргасан албан хаагчдыг шагнаж урамшуулж ажиллалаа. Энэхүү арга хэмжээний хүрээнд Сүхбаатар-Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ын 5 албан хаагчдад тус бүр 1 сая, эмч эмнэлгийн мэргэжилтнүүдийг шагнаж урамшуулахад нийт 15,2 сая төгрөгийг тус тус зарцуулаад байна.	100
		2.5.3 Орон нутгийн хөгжилд оруулсан хувь нэмэр, ажлын үзүүлэлтийг харгалзан жил бүр албан хаагчдыг шалгаруулан урамшуулж байх журам боловсруулан хэрэгжүүлэх	Монгол Улсын болон Сүхбаатар аймгийн нийгэм эдийн засгийг хөгжүүлэх, орон нутгийн хөгжил дэвшил, бүтээн байгуулалтад гар бие оролцож өндөр амжилт гаргасан, хөрөнгө санхүү, эд материалын бодитой дэмжлэг үзүүлсэн, онц чухал үүргийг нэр төртэй биелүүлсэн, онцгой нөхцөлд идэвх зүтгэл гарган ажилласан, орон нутагтаа он удаан жил үр бүтээлтэй хөдөлмөрлөж эрхэлсэн ажилдаа амжилт гаргасан төрийн болоод төрийн бус байгууллагын ажилтан, албан хаагчид, малчид, соёл урлаг, биеийн тамир спорт, ахмад, бизнесмен болон байгууллага хамт олныг жил бүр шалгаруулан, урамшуулан ажиллаж байна. Дээрх салбарын тэргүүний ажилтан болон шилдэг байгууллага хамт олныг 800,000-1,500,000 төгрөгөөр шагнаж, урамшуулсан.	100
		2.5.4 Албан хаагчдын ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, тэдний ажлын байрны стрессийг бууруулах, сэтгэл ханамжийг нэмэгдүүлэхэд анхаарах	Төрийн албаны тухай хуульд заасны дагуу төрийн байгууллагууд албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг боловсруулан, хэрэгжилтийг нь хангах, хэрэгжүүлэх зардлыг жил бүрийн төсөвт тусгаж байхыг үүрэг болгоод байна.	100
		2.5.5 Төрийн албан хаагчдын ур чадвар, чадамжийг үнэлэх аргачлал боловсруулан 2 жил тутам чадамжийн түвшнийг тогтоон өндөр чадамжтай албан хаагчдыг урамшуулна.	Энэхүү хөтөлбөрийг боловсруулах ажлын хүрээнд албан хаагчдын ур чадвар, чадамжийн үнэлгээний загвар болон аргачлалыг боловсруулаад байна. Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт энэхүү үнэлгээг хийхээр тусгаад байгаа ба 2025 онд албан хаагчдын ур чадвар, чадамжийн үнэлгээг хийхээр төлөвлөөд байна.	80

		2.5.6 Аймгийн төвд тасралтгүй ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчид таван жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгох асуудлыг судалж шийдвэрлэнэ.	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 83 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу аймгийн төвийн суманд ажиллаж буй журамд заасан болзол шаардлагыг хангасан төрийн захиргааны албан хаагчдад 6 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг олгоод байна.	100
9	2.6. Төрийн албаны удирдлагын манлайллыг сайжруулах	2.6.1 Төрийн байгууллагын удирдлагуудын манлайлах ур чадварыг хөгжүүлэх сургалтуудыг тогтмол зохион байгуулж, чадавхыг дээшлүүлэх	2024 оны удирдах ажилтны зөвлөгөөний үеэр “Харилцааны ур чадвар, удирдах арга барилын харилцан хамаарал”, Манлайлал ба нөлөөлөх ур чадвараа хөгжүүлэх нь, “Тэгш оролцоог хангах, жендерийн мэдрэмжтэй удирдагч байх нь”, “Женерэшн буюу үе хоорондын ялгаа, онцлог, Багийн ажиллагааг дэмжих нь”, “Технологи ашиглаж ажлаа хөнгөвчлөх нь”, " Боломж гэж юу вэ " зэрэг 8 цагийн сургалтыг зохион байгуулсан. Уг сургалтад 15 сая төгрөг зарцуулаад байна.	100
		2.6.2 Удирдлагын манлайллын үнэлгээг жил бүр хийж, үнэлгээний мөрөөр урамшуулал, хариуцлага тооцох	Удирдах албан тушаалтны манлайллыг үнэлэх аргачлал, судалгааны асуулга боловсруулах ажлыг хийж байна. Энэхүү судалгааны асуулга боловсруулах ажлын хүрээнд 4 төрлийн асуулгыг боловсруулан 2024 онд аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, хэлтсийн дарга нарын манлайллыг үнэлэх туршилтыг хийж үзэхэд 61,3 хувьтай байна. Энэхүү судалгааг дахин шинэчлэлт, сайжруулалтыг хийж аймгийн хэмжээний төрийн албаны удирдах албан тушаалтнуудын манлайллыг тодорхойлох ажлыг 2025 онд хийхээр төлөвлөөд байна.	100
		2.6.3 Ажлын байран дээр болон өөрөө байнга суралцагч, манлайлагч байх, орчин үеийн менежментийн чиг хандлагад суралцах арга барилд тасралтгүй суралцуулах	Байгууллага удирдах албан тушаалтнуудыг сурч хөгжих боломжоор ханган ажиллаж байна.	100
Хэрэгжилтийн дундаж хувь				97,2